



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/153

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3, Усны тухай хуулийн 12.1.4, 12.1.3 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлгэрхаан сумын Аварга тосон нуурыг хамгаалах, нөөцийн болон гидрогеологийн судалгааг хийлгэх, амралт, сувиллын үйл ажиллагааг нэг жилийн хугацаатай түр зогсоох арга хэмжээг зохион байгуулах, шийдвэрлэх, нуурыг нөхөн сэргээх чиглэлээр ажлын даалгавар, төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч:  
Нарийн бичгийн  
дарга:

Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Усны асуудал хариуцсан мэргэжилтэн

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн

Хэрлэн голын сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн

Ус, цаг уур орчны шинжилгээний газрын Ус, судлалын судалгааны инженер

Татварын хэлтсийн Орлогын тасгийн дарга

Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч

Мэргэжлийн хяналтын газрын Эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч

721010408

2.

Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар  
хамгааллын хяналтын улсын байцаагч

Дэлгэрхаан сумын Засаг дарга

Аварга тосон рашаан ус хамгаалах нийгэмлэг Төрийн бус  
байгууллагын тэргүүн /тохиролцсоноор/

2. Нуурын усны түвшин, нөөц, гидрогеологийн судалгааг хийлгэж, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр ажлын даалгавар, төлөвлөгөөг боловсруулан зохион байгуулалтын арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэх, холбогдох дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах, тухай бүр тайлагнаж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/204 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА